

[Өвөрхангай аймгийн Төгрөг сум]

БАТЛАВ
ЗАСАГ ДАРГА  Б.БАТБАЯР

2020 оны 02 дугаар сарын 04 өдөр



[ХҮНС ЭРХИЙН БИЧГЭЭР ҮЙЛЧЛЭХ ХҮНСНИЙ ДЭЛГҮҮР СОНГОХ]
НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалт /
гэрээний дугаар:

ӨВАТСЗДТГ/202001016

ХООЛТ
2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Өвөрхангай аймгийн Төгрөг сумын Засаг даргын тамгын газар] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[Төгрөг сумын хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх бүтээгдэхүүнээр үйлчлэх хүнсний дэлгүүр сонгох]**-ыг нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: төсөвт өртөгийн 30% түүнээс дээш
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: төсөвт өртөгийн 30% түүнээс дээш
Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2019 он
Улсын бүртгэлийн гэрчилгээ
Захиралын иргэний үнэмлэх
Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас гэрээ дүгнэсэн актыг заавал авч тендерийн материалд ирүүлэх

Үнийн саналыг улирлын чанартай бүтээгдэхүүн дээр зун намар болон хавар өвлийн улирлаар үнийн санал ирүүлэх

Үнийн саналыг **[2020 оны 02 дугаар сарын 11-ны 10 цаг 00 минут]**-аас өмнө **[Өвөрхангай аймгийн Төгрөг сумын ЗДТГазрын 2 давхарт 01 тоот өрөө, Утас 99959290]** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 02 дугаар сарын 11]**-ны өдрийн **[10 цаг 30 минут]** -т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх : Тийм

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**[Өвөрхангай аймгийн Төгрөг сумын ЗДТГазрын 2 давхарт 01 тоот өрөө,
Утас 99959290]**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ
4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналыг хүлээж авна.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ

байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [1] 2019 оны жилийн санхүүгийн тайлан Сүүлийн 1 жилд ашигтай ажилласан байх ба борлуулалтын орлого нь төсөвт өртөгийн 30% түүнээс дээш Бусад нэмэлт шаардлага; Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар Тендерт оролцогч нь :</p> <ol style="list-style-type: none">1. Тендерт оролцогч нь боловсруулсан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг электрон хэлбэр /Adobe PDF/ -т хөрвүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ.2. Уг тендер цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь төрийн худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn – д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг /PKI/ -ээр нэвтрэн орж материалыг цахимаар авч, тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.3. Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас гэрээ дүгнэсэн актыг заавал авч тендерийн материалд ирүүлэх4. Үнийн саналыг улирлын чанартай бүтээгдэхүүн дээр зун намар болон хавар өвлийн улирлаар үнийн санал ирүүлэх
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: [Өвөрхангай аймгийн Төгрөг сумын Өлзийт 1-4 тоот] Давхар болон өрөөний дугаар: [Өвөрхангай аймгийн Төгрөг сумын ЗДТГазрын 2 давхарт 01 тоот өрөө] Огноо: [2020 оны 02 дугаар сарын 11-ны өдөр] Цаг: [10 цаг 00 минут]</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: [Өвөрхангай аймгийн Төгрөг сумын Өлзийт 1-4 тоот] Давхар болон өрөөний дугаар: [Өвөрхангай аймгийн Төгрөг сумын ЗДТГазрын 2 давхарт 01 тоот өрөө] Огноо: [2020 оны 02 дугаар сарын 11-ны өдөр] Цаг: [10 цаг 30 минут]</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багц -1 : Хүнсний бүтээгдэхүүн, Сүү сүүн бүтээгдэхүүн, Мах махан бүтээгдэхүүн, Хүнсний ногоо</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нэг дор нь дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

- ✚ Хүнс нийлүүлэх байгууллагын оновчтой сонгох
- ✚ Хүнс нийлүүлэгч байгууллагаас зах зээлийн хамгийн бага боломжит үнээр хүнсний бүтээгдэхүүн худалдан авна
- ✚ Хүнс нийлүүлэгч байгууллагаас эрүүл ахуйн болон хүнсний аюулгүй байдлын тухай зохих хууль, дүрэм, журам, шаардлагыг хангасан бүтээгдэхүүнийг нийлүүлнэ.

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- ✚ Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байна
- ✚ Хүнсний бүтээгдэхүүн нь шинжилгээний бичигтэй байна
- ✚ Нийлүүлж буй бүтээгдэхүүн нь сав баглаа боодол шошготой байх
- ✚ Бараа, бүтээгдэхүүн нь гарал үүслийн болон лабораторын бичигтэй байх
- ✚ Бараа бүтээгдэхүүн өдөр тутам нийлүүлэх боломжтой байх
- ✚ Худалдаа үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй байх
- ✚ Хүнсний бүтээгдэхүүн нь мэргэжлийн хяналтын байгууллагаас гарсан шаардлага шалгуурт нийцсэн байна.
- ✚ Хүнсний бүтээгдэхүүн хадгалах хугацааг нарийвчлан бүртгэж хөтөлдөг байх
- ✚ Гэрээгээр хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлнэ
- ✚ Өрхийн 18-аас дээш насны иргэн бүр сард 16000 төгрөг, хүүхэд 8000 төгрөгийн хүнсний талноор бүтээгдэхүүн худалдан авна.
- ✚ Мах сүү гуртлаг бүтээгдэхүүн нь импортын бус байх
- ✚ Хүнсний эрхийн бичгээр хүнс олгох өрхөд бүтээгдэхүүний үнийг нэмж борлуулахгүй, зүй бусаар харьцахгүй, жин дутуу өгөхгүй, заасан нэр төрлөөс бусад бүтээгдэхүүн худалдахгүй байх

Төгрөг суманд хүнсний эрхийн бичгээр үйлчилнэ

Нэр төрлийн дугаар	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	ᠬᠠᠶᠢᠨᠠᠳᠤᠶᠢᠨᠭᠡᠷᠭᠡᠨᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠠᠨ
1. Гурил гурилан бүтээгдэхүүн /импортын бус/	Гурил /1 дүгээр алтан тариа, есөг, улаанбаатар, ургац, өөгтэй дүйцэхүйц /	Кг	Гурил гурилан бүтээгдэхүүн худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн байх бөгөөд бялуу, кекс хамаарахгүй. Импортын бус байна. бүтээгдэхүүний нэр төрөл хэмжээг зааж ирүүлнэ. Үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа болон бусад нөхцөл тодорхой заагдсан, чанарын шаардлага хангасан сав баглаа боодол бүрэн бүтэн, тээвэрлэлтийн горим алдагдаагүй байх. Бүтээгдэхүүний гарал үүслийн бичгийг ирүүлнэ.
	Боорцог	Кг	
	Талх	Кг	
	Еэвэн	Кг	
	Печень	Кг	
2. Мах, дайвар бүтээгдэхүүн /импортын бус/	Бүх төрлийн малын мах	Кг	Мах дайвар бүтээгдэхүүнд худалдан борлуулахаар зөвшөөрөгдсөн бүх төрлийн малын мах. Малыг гэдэс дотор толгой шийр орно. Хиам болон лаазалсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн орохгүй. Гарал үүслийн гэрчилгээтэй, эрүү ахуй чанарын шаардлага хангасан тарган, өвчин эмгэггүй байх тухайн малыг эрүүлжүүлэх
	Малын гэдэс Дотор	Кг	
	Толгой шийр	ш	

			зорилгоор вакцин болон ивомек тарилга хийлгэсэн бол тарилга хийлгэсэн хугацаа нь уг малыг худалдан авахаас 21-ээс доошгүй хоногийн өмнө байх. Импортын бус байх
3.Сүү, сүүн бүтээгдэхүүн /импортын бус/	Сүү	Кг	Сүү сүүн бүтээгдэхүүн гэдэгт хуурай болон шингэ сүү, тараг, аарц хамаарна. Сүү нь өдөр тутмын шинэ байна. бүх бүтээгдэхүүн гарал үүслийн гэрчилгээтэй байх. Тараг исгэлэн байж болохгүй нийлүүлэх хугацаанаас хамааран малын сүү, үйлдвэрийн сүүний үнийг салгаж өгөх
	Аарц	Кг	
	Тараг	Кг	
4.Хүнсний ногоо	Төмс	Кг	Төмс хүнсний ногоо гэдэгт дарсан ногоо буюу лаазалсан, даршилсан, дахин боловсруулсан бүтээгдэхүүн хамаарахгүй. Нутгийн хөрсөнд ургасан монгол сортын гарал үүсэл тодорхой шинэ ургац үүсээгүй байна.
	Байцаа	Кг	
	Лууван	Кг	
	Манжин	Кг	
	Сонгино	Кг	
5.Будаа	Бүх төрлийн будаа	Кг	Будаанд бүх төрлийн будаа, хүүхдийн будаа, үр тариа, шар буурцагийн гаралтай бүтээгдэхүүн хамаарна. Үйлдвэрлэгдсэн огноо, хадгалах хугацаа болон бусад нөхцөл тодорхой заагдсан, чанарын шаардлага хангасан, сав баглаа боодол бүрэн бүтэн, тээвэрлэлтийн горим алдагдаагүй байх гарал үүслийн шинжилгээний бичгийг ирүүлнэ
6.Ургалмын тос	Бүх нэр төрлийн дотоодын ургамлын тос	ш	Үйлдвэрлэгдсэн огноо, хадгалах хугацаа болон бусад нөхцөл тодорхой заагдсан, чанарын шаардлага хангасан, сав баглаа боодол бүрэн бүтэн, тээвэрлэлтийн горим алдагдаагүй байх гарал үүслийн шинжилгээний бичгийг ирүүлнэ
7.Өндөг	Өндөг	ш	Хадгалалтын шаардлага хангасан байна. хадаглах хугацааны он сар өдөр тодорхой байх
8.Цөцгийн тос	1. дотоодын үйлдвэрийн цөцгий 2. масло 3. цагаан тос өрөм	Кг	Үйлдвэрийн шаардлага хангасан шинэ нэр төрлийг тодорхой заасан байх. Гарал үүслийн шинжилгээний бичгийг ирүүлнэ
		Кг	
		Кг	
9.Элсэн чихэр	Элсэн чихэр	Кг	Үйлдвэрлэгдсэн огноо, хадгалах хугацаа болон бусад нөхцөл тодорхой заагдсан, чанарын шаардлага хангасан, сав баглаа боодол бүрэн бүтэн, тээвэрлэлтийн горим алдагдаагүй байх гарал үүслийн шинжилгээний бичгийг ирүүлнэ
10.Жимс жимсгэнэ	1. Алим 2. Мандарин	Кг	Жимс жимсгэнэд компот, жимсний чанамал, хатаасан жимс хамаарахгүй. Үйлдвэрлэгдсэн огноо, хадгалах хугацаа болон бусад нөхцөл тодорхой заагдсан, чанарын шаардлага хангасан, сав баглаа боодол бүрэн бүтэн, тээвэрлэлтийн горим алдагдаагүй байх
		Кг	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:

1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.] |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Гэрээний үнийн дүнгийн [moo] хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | 9.1. Алданги оногдуулах хувь: [moo]

Алдангийн нийт дүн: [moo] |

Долоо. **ГЭРЭЭНИЙ МАЯГТ
БАТЛАВ.**

ЗАХИАЛАГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ____ дугаар сарын ____-наас _____ оны ____ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг²;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв

- гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
 7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
 8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]